



СОЁМБОМ ЭДЭЭ

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№100 /544/

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

2023.06.20

Цаг үе, үйл явдал

“ЭМЭГТЭЙЧҮҮД, ЭНХ ТАЙВАН БА АЮУЛГҮЙ БАЙДАЛ” СЭДЭВТ СЕМИНАРЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ БАЙНА



Энэ цаг мөчид Монгол Улсын Зэвсэгт хүчний Жанжин штаб, Номхон далай дахь АНУ-ын Хуурай замын цэргийн командлалтай хамтран “Хааны эрэлд-2023” энхийн ажиллагааны олон улсын сургуулийн чадавхыг нэмэгдүүлэх сургалтын хүрээнд “Эмэгтэйчүүд, энх тайван ба аюулгүй байдал” сэдэвт семинарыг зохион байгуулж байна.

Тус семинар нь эмэгтэйчүүд, энх тайван ба аюулгүй байдал чиглэлээр НҮБ-аас гаргасан тогтоолуудыг цэргийн алба хаагчдад сурталчлан таниулах, Энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх үед аливаа бодлого, шийдвэрийг жендерийн талаас харж мэдрэмжтэй шийдвэр гаргахад шаардлагатай мэдлэг, чадварыг олгох зорилготой юм.

Семинарыг нээж ЗХЖШ-ын Энхийг дэмжих, цэргийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга хурандаа Ж.Молорболд хэлсэн үгэндээ “Монгол Улс, АНУ-тай цэргийн хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд онцгой анхаарч ажилладаг. Хоёр улсын Зэвсэгт хүчний хамтын ажиллагааны хүрээнд хэрэгждэг томоохон арга хэмжээний нэг нь 2003 оноос эхлэн зохион байгуулж буй “Хааны эрэлд” энхийн ажиллагааны олон улсын сургууль юм. “Хааны эрэлд-2023” энхийн ажиллагааны олон улсын сургуулийн чадавхыг нэмэгдүүлэх сургалтын хүрээнд “Эмэгтэйчүүд, энх тайван ба аюулгүй

байдал” сэдэвт семинарыг бид хоёр дахь удаагаа зохион байгуулж байна.

Тус семинар нь энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх алба хаагчдыг бэлтгэх, тэр дундаа энхийг сахиулах ажиллагаанд үүрэг гүйцэтгэх үед жендерийн мэдрэмжтэй шийдвэр гаргахад шаардлагатай мэдлэг, чадварыг цэргийн алба хаагчдад эзэмшүүлэхэд ихээхэн ач холбогдолтой юм. Тийм ч учраас семинарт хамрагдах бүрэлдэхүүнийг зөвхөн Монгол Улсын Зэвсэгт хүчнээр хязгаарлахгүй, ЦЕГ болон Төрийн цэргийн байгууллагын төлөөллийг хамруулахаар төлөвлөсөн. Уг семинарт хүрэлцэн ирсэн хүндэт зочид төлөөлөгчид та бүхэнд талархал илэрхийлэхийн зэрэгцээ семинарыг зохион байгуулах боломж олгож, Монгол Улсын Зэвсэгт хүчний алба хаагчдын мэдлэг, ур чадварт үнэтэй хувь нэмэр оруулж буй Номхон далай дахь АНУ-ын цэргийн командлал болон Австрали, Фижи Улсаас хүрэлцэн ирсэн сургагч багш нарт талархал илэрхийлье” гэлээ.

Үргэлжлүүлэн АНУ-ын Цагдаагийн наймдугаар бригадын захирагч хурандаа Чарлис Грийн хэлсэн үгэндээ АНУ, Монгол Улстай цэргийн хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор “Хааны эрэлд-2023” энхийн ажиллагааны олон улсын сургуулийг зохион байгуулж буйд баяртай байна.

АНУ-ын Номхон далай дахь Хуурай замын цэргийн командлалын хувьд “Эмэгтэйчүүд, энх тайван ба аюулгүй байдал”-ыг нэмэгдүүлэх, сайжруулах үйл ажиллагааг цэргийн өдөр тутмын дасгал, сургуулилт, энх тайван болон аюулгүй байдлын төлөөх бодлого зорилтдоо тусгасан байдаг. “Эмэгтэйчүүд, энх тайван ба аюулгүй байдал” хэмээх сэдвийг хөндөх нь дан ганц эмэгтэйчүүдийн асуудал бус үүний ард байгаа нийгмийн эмзэг бүлэг болох хүүхэд, өндөр настнуудын аюулгүй байдлыг хангах, нэмэгдүүлэхэд ихээхэн ач холбогдолтой. Уг семинараар жендерийн эрх тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоо, эмэгтэйчүүдэд учирч буй бүхий л төрлийн хүчирхийлэл, ялгаварлан гадуурхалтыг таслан зогсооход хувь нэмэр болохуйц санал санаачилгыг хамтран боловсруулна гэдэгт итгэлтэй байна” хэмээсэн юм.

Семинарт Монгол Улсын Зэвсэгт хүчин болон ЦЕГ, ОБЕГ, ХХЕГ, ШШГЕГ-ын 50 орчим алба хаагчид хоёр ээлжээр хамрагдаж буй бөгөөд эхний ээлжийн сургалт 6 дугаар сарын 20-22, хоёр дахь ээлжийн сургалт 6 дугаар сарын 26-29-ний өдрүүдэд тус тус зохион байгуулагдах ба семинарыг Номхон далай дахь АНУ-ын ХЗЦК-аас хоёр, Австрали Улсаас нэг, Фижи Улсаас нэг, Монгол Улсын Зэвсэгт хүчнээс нэг нийт дөрвөн багш удирдаж явуулах юм.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 23	🌧️ 7

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 34	🌧️ 24

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,429	3,437
EUR 🇪🇺	3,739	3,779
CNY 🇨🇳	482	487
RUB 🇷🇺	39	40
JPY 🇯🇵	24.25	24.70
KRW 🇰🇷	2.62	2.65

ЗУРХАЙ



2023.06.20 /МЯГМАР ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 2

ЗУНЫ ДУНД ШАР МОРЬ САР ДОЛООН УЛААН МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ТАХИА ӨДӨР

Үс засуулбал:

Нас ахар болно

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

04.53-20.55

Барилдлага:

Хүчин төгсөх

ШҮТЭН БАРИЛДЛАГА:

Сэрэхүй

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Эл өдөр буян үйл үйлдвээс элзийтэй, өргөл хүндлэл, бурханд соёрхол тавих, амирлуулах, дэлгэрүүлэх, эрхшээх үйл нигууд бүтээхэд сайн, амраг лугаа золгох, авшиг авах, ус гатлах, угаах зэрэгт сайн. Баруун нүд татвал садан ирэх, зүүн нүд татвал баярлах, баруун чих хангинавал гутамшиг болох, зүүн хангинавал завхарсныг сонсож цочих, бие татвал өмнө зүгээс зочин ирэх, хөл татвал хэрүүл гомдол болно.

МЭРГЭЖЛИЙН АХЛАГЧ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ШАЛГАЛТ ЯВАГДАЖ БАЙНА



Зэвсэгт хүчний Хуурай төгсөлтийн шалгалтыг 2023 оны 06 замын “Ахлагчийг хөгжүүлэх төв”-ийг дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн түшиглэн мэргэжлийн ахлагч бэлтгэх төвийн сургалт амжилттай явагдаж байгаа билээ. Ахлагч бэлтгэх төвийн мэргэжлийн стандарт, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийг бүрэн хангасан суралцагчдын

Улсын шалгалтыг Хуурай замын цэргийн командлагчийн тушаалаар томилогдсон комиссын бүрэлдэхүүн жижиг бүлгийн тактик, галын бэлтгэл

хичээлээр онол, буудлагын дасгал, биеийн тамирын цогцолбор шалгалтыг салаа тус бүрээр зохион байгуулж байна.

Мэргэжлийн ахлагч бэлтгэх төвд суралцаж буй цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба

хаагчид өөрийн ур чадвар, тэсвэр тэвчээр, оюун ухааныг уралдуулан идэвхтэй хамрагдаж буй нь цаашид албан үүргээ гүйцэтгэхэд бэлэн байгааг илтгэж байсан юм.

Ахлах дэслэгч Ц.БАДАМСҮРЭН



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 690,599,465

Эдгэрсэн

Нийт: 663,054,892

Нас барсан

Нийт: 6,893,845

Цахим шууданд

ХАНГАЙН БҮСИЙН ОЮУТАН ЦЭРГҮҮДИЙН СУРГАЛТ ЭХЭЛЛЭЭ



Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн Сургалтын төвд Сэлэнгэ, Булган, Хөвсгөл, Орхон аймгаас “Оюутан цэрэг-2023” сургалтад хамрагдсан 103 суралцагч цэргийн мэргэжлийн сургалтад хамрагдаж эхэллээ.

Сургалтын эхний өдрийг суралцагчид “Цэргийн дүрэм”, “Жагсаалын бэлтгэл”-ээр эхлүүлсэн бөгөөд хичээлийг залуу офицер, ахлагчийн манлайлал дор шинэлэг арга хэлбэрээр зохион байгуулан явуулж байна.

Шинэхэн оюутан цэргүүд сургалтын арга барил, материаллаг бааз, ахуй хангалт, хоолны амт чанарт сэтгэл хангалуун байгаагаа илэрхийлж байсан юм.

Хошууч
О.ОТГОНЦЭЦЭГ

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН УДИРДАХ ГАЗРЫН БҮРЭЛДЭХҮҮН ХОЁРДУГААР ШАТНЫ ҮЗЛЭГТ ХАМРАГДЛАА



“Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагчийн нэрэмжит төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын алба хаагчдын ёс зүй, бие бялдрын бэлтгэлжилтийн түвшин тогтоох хоёрдугаар шатны үзлэг”-т Барилга-инженерийн цэргийн удирдах газрын бие бүрэлдэхүүн энэ сарын 20-ны өдөр батлагдсан удирдамжийн дагуу хамрагдлаа.

Үзлэгийг Удирдах газрын даргын тушаалаар томилогдсон Ажлын хэсэг “Бие бялдарын бэлтгэлжилтийн түвшин”, “Цэргийн нийтлэг дүрэм”-ийн шалгалт, ёс зүй болон сэтгэл зүйн байдлыг тодорхойлох асуумж, дүрэмч жагсаалч байдал зэрэг үзүүлэлтүүдээр шалгаж үнэлсэн.

Цаашид батлагдсан удирдамжийн дагуу Удирдах газрын харьяа зарим ангиудад хоёрдугаар шатны үзлэгийг явуулахаар төлөвлөн ажиллаж байна.

ЯПОН УЛСЫН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИД МАЛЧНЫ ХОТОНД ЗОЧЛОВ



Монгол Улс, Япон Улсын хамтарсан “Зам-2023” сургалтад оролцож буй Япон Улсын Зэвсэгт хүчний сургалтын бүлгийн бүрэлдэхүүн энэ сарын 20-ны өдөр Төв аймгийн Алтанбулаг сумын малчин Ж.Бямбажавын зочилж, Монгол ёс заншил, өв уламжлал, малчин айлын амьдрал ахуйтай танилцлаа.

Хүрэлцэн ирсэн зочдоо гэрийн эзэгтэй цагаан идээ болон айргаа сөгнөн дайлж Монгол түмний зочломтгой зан чанарыг харуулан хүндэтгэж, тэдэнд мал маллах арга ухаан, цагаан идээг хэрхэн боловсруулдаг, түүнийг хэрэглэхийн ач холбогдлын талаар тайлбарлан танилцууллаа.

Ташрамд сонирхуулахад Япон Улсын цэргийн алба хаагчдад Монгол орны удам газар нутаг, амгалан тайван малчин амьдрал ихэд таалагдсаны зэрэгцээ малчин айл телевиз, хөргөгч, ухаалаг гар утас, интернет ашиглан хотын амьдралтай ижил хэрэглээтэй байгаа нь тэдний гайхширлыг төрүүлсэн юм.

Ахмад Г.МӨНХБОЛД

Зарлал

УБХИС-ийн 2023-2024 оны хичээлийн жилийн ЭЛСЭЛТИЙН БҮРТГЭЛ эхэллээ.

ХӨТӨЛБӨР: ■ Бакалавр ■ Мэргэжлийн боловсрол

БҮРТГЭЛ: 06.19-07.06

Дэлгэрэнгүйг 11 453164, 11 451820 утсаар лавлана уу.

www.mndu.gov.mn

ХОВДЫН ДОМОГТ ХОРОО ОЮУТАН ЦЭРГҮҮДИЙГ ХҮЛЭЭН АВЛАА



Ардын Хатанбаатар Д.Уламбаяр томилогдсон бөгөөд С.Магсаржавын нэрэмжит, Цэргийн гавьяаны улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн Сургалтын төвд Ховд, Увс, Говь-Алтай, Завхан, Баян-Өлгий аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабаас татагдан ирсэн оюутан цэргүүдийг хүлээн авч сургалтад хамруулж эхэллээ.

Оюутан цэргийн Сургалтын төвийн даргаар Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн захирагчийн сургалт бэлтгэл хариуцсан орлогч хошууч

Энэ жил Монгол Улсын Засгийн газрын шийдвэрийн дагуу “Оюутан цэрэг” сургалтад хамрагдах залуусын тоог 1500 болгож нэмэгдүүлсэн ба үүний 425 суралцагч нь орон нутгийнх ажээ.

Дэслэгч
П.МАНДАХЦЭЦЭГ



ХОЛБООЧИН ДАЙЧИД “ЦУСНЫ ДОНОРЫН ӨДӨРЛӨГ”-Т НЭГДЛЭЭ



Жил бүрийн 06 дугаар сарын 14-ний өдрийг “Цусны донорын Дэлхийн өдөр”-ийг Дэлхий даяар нэгэн зэрэг тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай. “Цусны донорын өдөрлөг”-ийг Эрүүл мэндийн яам, Цус сэлбэлт судлалын үндэсний төвөөс Цусны донорын эгнээг өргөжүүлэх, донорын сургалт, сурталчилгааг хүн амын дунд түгээх, байнгын донорын тоог нэмэгдүүлэх зорилгоор цус цуглуулах үйл ажиллагааг төрийн болон төрийн бус байгууллага, их дээд сургууль, коллежуудтай хамтран зохион байгуулдаг байна.

Энэхүү өдөрлөгт Цэргийн гавьяаны улаан тугийн болон Алтан гадас одонт хошууч генерал Р.Гаваагийн нэрэмжит Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн бие бүрэлдэхүүн энэ сарын 20-ний өдөр нэгдэж цусаа хандивлалаа.

Тус ангиас байнгын бүрэлдэхүүн, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчийн нийт 60 гаруй цэргийн алба хаагч цусаа хандивлан цусны донорын эгнээнд нэгдсэн юм.

Дэслэгч
Н.УУГАНЦЭЦЭГ